

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-15

1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./	4-15
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 36 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, Д.Бум-Очир;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга, Ж.Энхбаяр;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, Г.Хосбаяр, Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, мөн газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал Д.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Э.Энхбаатар, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Д.Цэгмиддорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга П.Эрдэнэбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунзаяа, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Гэрэлмаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт А.Наранцэцэг нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн

талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 44 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Та бүхэнд ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Хажикберийн Жангабыл гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдэж байна. Ингээд Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудал. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газраас 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн барьсан. Өнөөдөр 06 дугаар сарын 26-ны өдөр.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Үндэсний аудитын газраас Монгол Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Цэгмэддорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Энхбаатар.

Гадаад харилцааны яамнаас Гадаад харилцааны дэд сайд Амартүвшин. Амартүвшин дэд сайд байна уу. Голлоод суугаарай. Тус яамны Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Отгонцэцэг, Сангийн яамнаас Сангийн сайд Мэндсайхан, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Анар, тус яамны Төрийн сангийн газрын дарга Хуягцогт, Тус яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Төрийн сангийн санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ганзориг. Ийм бүрэлдэхүүнтэй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдыг микрофонд урьж байна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэгдсэн тайланг нэгтгэн боловсруулж, “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33,7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,8 хувьд тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27,9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ 1,1 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд Байнгын хороонд харьяалагдах Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 65 төсөвт байгууллага, 1 төрөл сан, төрийн өмчийн 6 аж ахуйн нэгж, нийт 72 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. Тайлант онд тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 1 их наяд 289 тэрбум төгрөгт хүрч, 96,1 хувийн биелэлттэй, нийт зарлага ба зээлийн цэвэр дүн 1 их наяд 261 тэрбум төгрөг буюу 94 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн 9 төсөл, арга хэмжээнд 113,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 97 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Нэгдсэн төсвийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн даргыг микрофонд урьж байна.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товчлон танилцуулъя.

1.Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 59 тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 54 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 3 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2,5 тэрбум төгрөгийн 35 зөрчил илэрснээс 24,1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 468,5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлага хүргүүлж, 2 тэрбум төгрөгийн зөрчлийг залруулах, давтан гаргахгүй байх 22 зөвлөмж өгсөн байна. Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт залруулаагүй алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 5,7 хувиар өссөн дүн мэдээтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гадаад харилцааны сайдын төсвийн багцад 9,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээ, гүйцэтгэлээр 8,3 тэрбум төгрөгийн төгрөг буюу 86 хувийг санхүүжүүлсэн байна.

2.Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд 103 тайлан нэгтгэсэнээс 58 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 45 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй харьяа 52 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,05 тэрбум төгрөгийн 200 зөрчил илэрснээс 290,8 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт тогтоож, 7,2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 62 албан шаардлага, сахилгын шийтгэл хүлээлгэх тухай 2 албан шаардлага хүргүүлж, 2,5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 118 зөвлөмж өгсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Батлан хамгаалах сайдын төсвийн багцад 65,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ гүйцэтгэхээр төлөвлөснөөс 64,6 тэрбум төгрөг буюу 98,2 хувийг санхүүжүүлсэн байна.

3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын төсвийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэсэнээс 1 байгууллагыг санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 4,6 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр 3 зөвлөмж өгсөн байна.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзлээ.

1.Төсвийг төлөвлөсөн төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг үнэлэх боломжтой байдлаар тодорхойлж батлуулах. 2027 оны төсвийн төслийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээнд чиглүүлэн боловсруулж батлуулах.

2.Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төлөвлөхдөө сүүлийн 3 жилийн бүрдүүлэлттэй уялдуулж бодитой төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.

3.Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас яамны аппарат, яамны харьяа байгууллагуудад төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний урамшуулал олгосон бол ЗХЖШ-ь төрлийн цэргийн командлал нэгтгэл, анги салбаруудад урамшуулал олгогдоогүй байгааг анхаарах.

4.Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад олгогдсон тусгай хэрэгцээний газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад давхардаж газар олгогдож буй зөрчлийг арилгах чиглэлээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай хамтран ажиллаж, данс, бүртгэлд авах ажлыг зохион байгуулах.

5.Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаанд сонгон шалгаруулалтын баримт бичгийг батлагдсан тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, үнэлгээ хийх, холбогдох баримтыг иж бүрэн бүрдүүлэх.

6.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад анхаарах .

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сая албан тушаалтнуудыг бас дутуу танилцуулсан байна. Ард талын хуудсан дээр байжээ. Сангийн яамны бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан, бүртгэл хэлтсийн шинжээч Цацрал, мөн ахлах мэргэжилтэн Баяр-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Алтанхорол, ахлах мэргэжилтэн Буянхишиг гэсэн бүрэлдэхүүн байна.

Батлан хамгаалах яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг, тус яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Гансүх, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Оюунгэрэл, Зэвсэгт хүчний жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Эрдэнэбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Ариунбуян. Тус газрын Санхүү, ар талын газрын дарга хурандаа Мөнх-Эрдэнэ гэсэн бүрэлдэхүүн байна. Цөмийн энергийн комиссоос Гэрэлмаа, ажлын албаны Хамтын ажиллагааны хэлтсийн дарга гэсэн байна. Тогтвортой байдлын зөвлөлөөс Энхбат гишүүн хүрэлцэн иржээ.

Гишүүдийг хуралдаанд дуудъя. Чуулган дээр нэлээн байна уу. Тайлантай холбогдуулаад мөн аудитын дүгнэлт болоод танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Гишүүдийг бас дуудаарай. Нэмж асуултад орж болно. Асуулт асуух гишүүд байна уу. Наранбаяр гишүүнээр тасалъя. Наранбаяр гишүүн.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ төсвийн гүйцэтгэлийн асуудлаар ингээд Байнгын хороо дээр бас асуух боломж олдсонд баяртай байна. Тэгэхээр би

бол чуулганы хурал дээр Сангийн сайдаас асуугаад хариултаа авсан юм. Энэ торгуулийн орлогын асуудал бараг 200 тэрбумыг ингээд төлөвлөчихдөг. Ингээд эхнээсээ л ер нь торгож, орлогоо олно гэдгээ ингээд төлөвлөдөг явдал бол бас манай энэ төрийн албаныхныг энгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нар супермаркетуудад ажлаа хийж байгаа ийм хүмүүсийг бол торгох ийм сэдэл рүү нь түлхдэг хүмүүсийг торгуулийн дарамтад оруулдаг ийм тал байгаа юм биш биз дээ гэдгийг асууж байсан. Тэгэхээр энэ бол бодитой явдал. Ер нь бол иймэрхүү жижиг үйлдвэр, худалдаа наймаа эрхэлж байгаа хүмүүс бол торгуулаагүй хүн байхгүй байна лээ шүү дээ. Торгуулаагүй хүн байхгүй. Харин хэдэн удаа торгуулсан бэ гэдгийг л асуу гэсэн ийм л нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Энэ дээрээ бас төр анхаарах ёстой. Иргэдээ бол хөл хөсөр, гар газар амар, өөрөөр хэлбэл торгуулийн айдасгүй бизнесээ эрхлээд ингээд явах боломжийг олгох ёстой гэсэн ийм байр суурьтай байгаагаа дахин илэрхийлье.

Манай энэ Байнгын хороонд харьяалагддаг 2 яамны тухайд бол Гадаад харилцааны сайдын төсвийн зарлагын гүйцэтгэлийг харахаар энэ дээр төсөв, байгууллагын өөрийн орлого нь 2 хуваагдаад үндсэн ба туслах гэж ингэж хуваагдаж байна. Нийтлэг татварын бус орлого гээд. Тэгээд энэ төсөвт байгууллагын өөрийн орлогын туслах хэсэг дээр жишээлэх юм бол 100 сая төгрөгийн орлогыг төлөвлөөд, 5,2 тэрбум төгрөг буюу энийгээ бараг хэд дахин өсгөсөн гэсэн үг үү. 50 дахин өсгөсөн гэсэн үг байна шүү дээ. Ийм орлого олсон байна. Тэгэхээр энэ ямар учиртай орлого байна вэ. Тэгээд яагаад ингэж их зөрүү гарсан юм бэ. Төлөвлөлт дээр ямар нэгэн асуудал байсан уу гэж асууя.

Мөн төсөвт байгууллагын өөрийн үндсэн орлого нь татварын бус орлого дээр бас 203 хувиар биелүүлсэн байгаа юм. Тэгэхээр үүний учир начир нь юу байдаг юм бэ гэдгийг асууя.

Батлан хамгаалахын яам ч гэсэн ер нь бол бас энэ төсөвт байгууллагын өөрийн орлогын үндсэн хэсэг дээрээ бол нийтлэг татварын бус орлогоо 122 хувь ингэж давуулан биелүүлсэн байна. Тэгэхээр энэ ямар учиртай орлого нь ийм сайн биелээд, дээр нь нэмээд ийм их хэмжээний байдлаар нугарч орж ирдэг юм бэ. Энийг бас хэрвээ боломжтой бол хариулт өгнө үү гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүнд баярлалаа. Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Ээлжлээд гараа өргөөд хариулаад яваарай. 2 номер. Эхлээд Сангийн яам, дараа нь Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам дараа нь. 2 номер.

Б.Анар: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Анар. Хүү, торгуулийн орлого бол хуулиараа орон нутгийн төсвийн орлого байдаг. Засгийн газар бол энэ хүү, торгууль дээр ийм хэмжээтэй байна гэдэг хэмжээг бол тогтоодоггүй. Тухайн орон нутаг, аймаг бол аймаг, орон нутагтаа нийслэл нь өөрөө тогтоогоод явж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа. 2025 оны төсвийн тодотгол дээр бол хүү, торгуулийн орлого бол 121,3 тэрбум төгрөг ер нь байх юм байна гэсэн суурийг нь бол тооцсон. Гэхдээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар энийг бол 270,1 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлээд баталчихсан байдаг. Яг 2025 оны хувьд гүйцэтгэл нь бол өөрөө 240,9 тэрбум төгрөг буюу 90,3 хувьтай гарсан. Энэ нь өөрөө нэгдсэн төсвийн нийт орлогын 0,7 хувьтай тэнцэж байгаа. Хүү, торгуулийн орлогын энэ дүнг яаж тавьдаг вэ гэхээр энэ орлого орж ирж байгаа учраас орлогын зардлын ангилал талдаа заавал тодорхой дүнгээр нөгөө төлөвлөгөө баталж тавихгүй бол эргээд гүйцэтгэл ямар байна вэ гэдгийг харж болдоггүй. Тэгэхээр хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө ямар зарчмаар төлөвлөдөг вэ гэхээр өнгөрсөн

жилийн гүйцэтгэлийг нь ерөнхийдөө суурь болгоод авчихдаг. Тэрнээс биш ийм хүмүүс заавал торгууль тавьж байж энэ орлогыг төвлөрүүлнэ гэдэг төлөвлөлт бол хийдэггүй байгаа.

Г.Тэмүүлэн: 6 номер.

Г.Амартүвшин: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааны сайдын багцад 2025 онд бол 3,1 тэрбум төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдсан байна. Тэгээд үүнээс дипломат төлөөлөгчийн газруудын тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогоос 3 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас үндсэн үйл ажиллагааны орлого 6,1 тэрбум төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 5,1 тэрбум, нийтдээ 11,2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Ер нь бол энэ орлого үндсэндээ дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн үйл ажиллагааны орлогод нь бол иргэдэд үзүүлдэг консулын үйлчилгээ, иргэний бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан орлогууд багтдаг юм байна. Бас визийн наадаг хуудасны орлого, визийн хураамжийн орлого. Тэгэхээр бол тухайн жилд хэчнээн иргэн консулын үйлчилгээ авах, өмнө нь явж ирсэн дундаж жишгээр нь үндсэндээ энэ төлөвлөлтийг хийгээд 2025 онд бол иргэдэд үйлчилсэн тоо нь нэлээн өндөр өсөлттэй гарснаас энэ төлөлт дээр 1 ийм зөрүү гарсан юм байна.

Г.Тэмүүлэн: Батлан хамгаалах яам хариулъя. 5 номер.

Д.Ганхуяг: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Батлан хамгаалах салбар бол төсвийн орлого биелүүлэн ажилласан. Төсвийн орлого бол голчлон туслах аж ахуйн орлого, түрээсийн орлого гэж байгаа. Энэ орлогыг бол 103 хувиар давуулан биелүүлсэн. Өөр бол тусгай зориулалтын янз бүрийн орлого бол байхгүй.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүн нэмж тодруулъя.

П.Наранбаяр: Хариулт өгсөнд баярлалаа. Тэгэхээр энэ дээр бид анхаарах зүйл нь бол орон нутаг хүү, торгуулийн орлого орон нутаг нь өөрөө мэддэг гээд ингээд явж байгаа. Улсын тогтоосон тэр өмнөх жилийн төлөвлөлтөөс бол байнга давуулан ингэж торгуулийн орлогыг ингэж явуулаад байгаа нь өөрөө бас нэг ийм цагдаа нарт болоод хяналтын байцаагч нарт торгох ийм сэдлийг бас их өгч байна. Ер нь бид бол торгуулийн орлого нь жил жилдээ буураад л явж байвал бас сайн нийгэм бүрдүүлж байна л гэсэн үг шүү дээ. Ер нь бол энэ чиглэлээр тэгээд 0,7 хувьтай тэнцэж байна гэхээр орон нутаг руу бол нөхцөл байдал их өөр байгаа шүү. Сая би бас зүүн аймгуудаар Сүхбаатар аймаг, Дорнод аймаг, мөн Хэнтийгээр яваад ирсэн. Тэнд бол яг л бизнес эрхлэгч нар ярьж байна лээ. Маш их торгуулж байна. Албан бичгийн хариу өгөөгүйгээс болж торгууллаа гээд сууж байна лээ шүү дээ. 1,5 сая төгрөгөөр. Ийм нөхцөл байдалтай байгааг бас анхаарах ёстой шүү гэдгийг төлөвлөгч нар анхаараарай. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ерөнхийдөө гишүүд асуулт асууж дууслаа.

Би хэд хэдэн асуултуудыг бас асууя. Би голлоод Аудит болоод Сангийн яамнаас тодруулж асуух зарчмын асуудлууд байгаа.

1 дүгээрт. Аудит төсвийн гүйцэтгэлийг өнөөгийн явж байгаа практикийг ер нь гүйцэтгэл бид нар бас энэ хэлэлцүүлэг, энэ төсвийн гүйцэтгэл дээр бас нэг талдаа тал талаасаа хариуцлагатай хандах бол бид нарт зайлшгүй шаардлагатай байгаа.

Үндсэндээ төсөв гэдэг өөрөө татвар төлөгчдийн мөнгө байдаг. Тэгээд бид нар энд зарцуулагдсан 1 төгрөг бүр дээр хариуцлагатай хандаж, энийг гүйцэтгэлийг нь шахаж шаардаж, илүү төсвийн сахилга бат болоод хариуцлагыг биелүүлсэн үү, үгүй юу гэдэг асуудлыг хянах зайлшгүй шаардлагатай. Одоогийн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа цаг хугацаа болоод дэгтэй холбоотой асуудлууд дээр аудит өөрөө яг ямар саналтай байна. Улсын Их Хурлын тухай хууль, Хяналт шалгалтын тухай хууль дээр бид нар бас энийг сайжруулах шаардлага байна уу, үгүй юу. Сангийн яам бас энэ асуудлууд дээр ямар байр суурьтай байна.

Аудитын дүгнэлт дээр ямар нэг санхүүгийн болон хуулийн хариуцлага хүлээлгэх, хүлээлгэсэн ийм тохиолдлууд гарсан уу. Бид нар 2023 онд орсон төсвийн тухай хуулиуд дээр анх удаагаа Төсвийн тухай хууль дээр хариуцлага хүлээлгэх нөхцөл, зүйл, заалтуудыг оруулж өгсөн. Бүр цаашлаад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр улс төрийн хариуцлага хүлээх эрхийг бас энүүгээрээ гаргаж ирсэн. Одоо ингээд үндсэндээ 2024, 2025 гээд 2 жилийн гүйцэтгэл орж ирэхэд аудитын байгууллагаас ямар нэг санхүүгийн болон улс төрийн хариуцлага хүлээлгэх зөрчлүүд илэрсэн үү. Дүгнэлт дээрээ та хэд тусгасан уу. Аудитын байгууллага ямар нэг Засгийн газрын болоод улс төрийн нөлөөнд орохгүйгээр хяналт, хариуцлага, үүргээ биелүүлэх энэ нөхцөл боломж бололцоо бүрдсэн үү. Ямар нэг байдлаар та бүхэнд нөлөөллийн үйл ажиллагаа бас байна уу, дарамт шахалт байна уу.

Би энэтэй холбоотойгоор 1 хуулийн шинэчлэлийг бас хүсээд байгаа. Аудитын байгууллагын удирдлагыг 1 хүний удирдлага дор биш хамтын удирдлагын тогтолцоонд шилжүүлэх ёстой гэдэг асуудлыг би бас хөндөж ярьсан. Өмнөх хавар болон хэлэлцүүлэг дээр бас энэ асуудлыг хөндөж тавьсан. Энэ хуулийн шинэчлэл болоод өөрчлөлтийн асуудлууд аудитын байгууллагыг хараат бусаар ажиллах энэ нөхцөлийг бүрдүүлэх тал дээр аудитын байгууллага ямар санаачилга, манлайлал гаргаж ажиллаж байна вэ.

2 дахь нь. Улсын төсвийн алдагдал. Сангийн яамнаас өнгөрсөн жилийн алдагдал 2025 оных 1,2 их наяд алдагдал үүссэн. Энийг хэрхэн санхүүжүүлсэн бэ. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас 2026 онд төлөх орлогоос нь урьдчилж шахаж шаардаж, урьдчилгаа төлбөрүүдийг авсан асуудлууд ярьж байна. 2026 оны орлогоос. Энэ ямар хуулийн хүрээнд, ямар нөхцөл, ямар зарчмын хүрээнд та бүхэн энийг бас шахаж шаардаж авсан, хэдэн төгрөг авсан, гүйцэтгэл нь ямар байгаа, мөн дээрээс нь Оюутолгой компанитай холбоотой татварын маргаантай гээд бас урьдчилгаа төлбөр байна уу. Ямар нөхцөлтэй, ямар байдлаар санхүүжилтийг авсан, хэдэн төгрөгийг хаана байршуулсан, юунд зарцуулсан энэ талаарх мэдээллийг өгнө үү.

Дээрээс нь 2025 оны 10 сараас хойш аудит ч гэсэн бас давхар энийг анхаарах хэрэгтэй. Өнгөрсөн онд намраас эхлээд төсвийн алдагдал үүсээд, төрийн үйл ажиллагаа саатаад, хүндрэл бэрхшээл санхүүжилтүүд ингээд хүндрэхэд үндсэндээ тодотгол хийхгүйгээр хүчээр тодотголын шахуу арга хэмжээг бол авсан. Орон нутаг дээр өнгөрсөн оны 10 сараас хойш 2026 оны 4 сар хүртэл үндсэндээ Сангийн яамнаас бүх санхүүжилтүүдийг гаргах эрхүүдийг хаасан. Орон нутгийн эрхэд халдсан. Ингээд үндсэндээ бараг зүгээр хамгийн энгийн жишээ мал тооллогод явах ёстой байсан орон нутгийн удирдлагууд тухайн төрийн үйлчилгээ явах асуудлууд бензиний ч мөнгөгүй болсон асуудлууд байгаад байгаа юм. Энэ ямар хуулийн үндэслэл болоод юуны хүрээнд та бүхэн ингэж хийсэн асуудлууд байна. Ер нь

цаашид бид нар юун дээр гарах юм. Ийм асуудлууд дээр хариулт авъя. Аудит 4 номер, дараа нь Сангийн яам 2 номер.

С.Магнайсүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэг дээр онцгой ач холбогдол өгөх ёстой гэдэг дээр санал 1 байгаа. Энэ 7 хоногийн өнгөрсөн Байнгын хороод бас ач холбогдол өгөх ёстой гэдэг ийм байр суурь бас олон гишүүд илэрхийлсэн. Бид нарын, манай Төрийн аудитын байгууллагын тухайд бол 1 зүйл ярьж байгаа. Тэр нь болохоор авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үнэлгээ хийж байгаа. Энэ хүрээнд бид нар бас тодорхой саналууд авлигатай тэмцэх байгууллагаас бас төсвийн гүйцэтгэл дээр ер нь онцгойлон ач холбогдол өгөх ёстой гэдэг ийм байр суурь бас байдаг. Энэ дээр бол манай 2 байгууллага бол санал нэгдэж байгаа. Тэгээд энийг бол өнөөдрийн эрх зүйн орчны хүрээнд ч бас хийж болохоор байгаа. Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулалт, хуваарийг нь сайн гаргаад, ингээд төсвийн ерөнхийлөн захирагчаар нь багцлаад юм уу, зарим сөрөг дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллагуудыг онцгойлон авчраад, зөрчил ихтэй байгууллагуудыг төсвийн ерөнхийлөн захирагчдын хүрээнд тусгайлан нэлээн нарийвчилж ярих ийм бололцоо бол байгаа юм. Тийм учраас бид нар энэ дээр бас анхаарал тавьж, дараа дараагийн удаад бол ийм байдлаар асуудлыг ярьж гэдэг ийм хүсэлт, санал солилцоод явж байгаа. Тухайлах юм бол Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр урьдчилсан уулзалт дээр бол энэ талаар ярьсан. Ирэх 7 хоногт бол Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дээр бид бас нэлээн нарийн ярих ийм бодолтой байгаа.

Ер нь бол хэлэлцүүлгийг сайжруулах тал бүрээс нь ярих асуудал бол зайлшгүй чухал байгаа гэдэгтэй бол тантай санал 1 байна. Бид энэ тал дээр бас тодорхой саналыг бололцоогоороо оруулж ирнэ гэж ингэж бодож байна.

2 дахь нь хариуцлагын асуудал бол нэлээн бид нар бас анхааралтай авч үздэг. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар тусгайлан зохион байгуулагдсан. 2025 онд бол 2024 онтой харьцуулахад харьцангуй 11,9 хувиар зөрчлийн дүн буусан боловч мөнгөн дүн бол ихэссэн байж байгаа. Тэр нь болохоор зэрэг давтамж нь буурсан боловч зөрчлийн дүн нэмэгдсэн байна гэдэг байдлаар бид нар анализ хийж үзээд, бүгд дээр нь үзсэн байж байгаа.

Хариуцлагатай холбогдуулаад бид нар нэлээн дэлгэрэнгүй мэдээллүүд бол энэ тайландаа тусгасан. Яг одоо Төсвийн хуулийн 70-тай холбогдуулаад хэлэхэд төсвийн хуулийн 70 дугаар зүйл дээр бол тодорхой заалтууд ингээд нарийвчлаад хийчихсэн. Энэ заалтуудаар бид нар нарийвчилж, бүх зөрчлүүдийг бол ялгасан байж байгаа. Аудитын цаглаварт хугацааны явцад бол бид нар Төсвийн ерөнхийлөн захирагчдын хүрээнд авч үзэхэд 105 этгээд, албан тушаалтанд бол хариуцлага хүлээлгэх ийм албан шаардлага хүргүүлсэн. Зарим 4 асуудлыг бол хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байж байгаа. Ингээд төсвийн 70 дугаар зүйлд заасан албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно, хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэсэн заалтуудыг авч үзээд, тэр хариуцлага хүлээлгэх, албан тушаалаас чөлөөлөх нь бол тэр эрх бүхий этгээд буюу хуулиараа эрх нь олгогдсон этгээдүүдэд хамаарч байгаа ийм асуудал байгаа учраас бид нар бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт бүх зөрчлүүдийг 70.1-д хамаарах нь тэд, тийм тийм байгууллага гээд бүгдийг нь жагсаалтаар ингээд хүргүүлсэн байгаа. Тухайлах юм бол Засгийн газрын харьяа байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нарын хүрээнд бол бид нар 842 байгууллага дээр 2868 зөрчлийг ялгаж, 1,1 их наяд төгрөгийн ийм зөрчлийг ялгаж хүргүүлсэн. Орон нутгийнхтайгаа Улсын Их Хурлын харьяа бусад бүх

байгууллагуудыг нэгтгэх юм бол бид нар 53 төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд 1423 байгууллагын 2915 зөрчлийг бол бид нар ялгаж хүргүүлсэн. Тухайлбал, хамгийн их нь Боловсролын сайдад бол бид нар 752 зөрчлийг энэ санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудынхаа хүрээнд энэ албан тушаалаас чөлөөлөх үндэслэл, хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон байна. Энэ хүрээнд нь холбогдох арга хэмжээг авч мэдэгдээч гэсэн ийм байдлаар бид нар ингээд бүх ерөнхийлөн захирагч нарт нь хүргүүлсэн. Тэгээд бид бол ирэх 7 хоногоос авхуулаад хамгийн өндөр зөрчилтэй байгаа төсвийн ерөнхийлөн захирагч нарын хүрээнд хэлэлцүүлгүүд хийж эхлэхээр хуваарь гаргасан. Манай Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газраас зохион байгуулаад энэ тал дээр бид нар онцгойлон анхаарч ингэж бол ажиллана гээд нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийг бол танд гаргаж өгөх бүрэн бололцоо байгаа.

Нөлөөлөл бол бидэнд харьцангуй байхгүй. Бид бол хараат бусаар ажиллах ийм хуультай учраас энэ хүрээндээ ажиллах бололцоо байгаа учраас энэ хуулиа бариад ингээд ажиллаж байгаа.

Хуулийн өөрчлөлтийн тухайд бол та хэллээ. Бид бол ер нь бол аудитын тогтолцоо бол шүүхийн тогтолцоотой, Ерөнхий аудиторын тогтолцоотой, хороо, зөвлөл, комисс буюу ийм хамтын удирдлагын тогтолцоотой, тэгээд холимог гэсэн нэг ийм 4, 5 хэлбэрүүд олон улсын жишгээр бол байгаа. Манай тогтолцоо бол Ерөнхий аудиторын тогтолцоотой ийм улс орнуудын хэлбэр төрөлд багтаж явдаг. Бид энэ талаар бол нарийвчлан судалж, одоогоор санал боловсруулсан зүйл алга байна. Нарийвчлан судлаад олон улсын аудитын байгууллагын зөвлөмж, чиглэл, жишиг, ерөнхий жишиг хөгжлийн чиг хандлагуудыг бол судлах ийм чиглэл өгөгдчихсөн, одоогоор судалгааны шатад байгаа учраас одоогоор танд энэ талаар тогтож хэлэх санал бол байхгүй байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 2 номер.

Б.Анар: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Анар. 5 асуулт асуусан. Эхнийх нь бол энэ төсвийн цаглавартай холбоотой асуулт асуусан. Гэхдээ төсвийн одоогийн байгаа цаглавар гэхээсээ илүүтэй төсвийн жилийн дундуур батлагдаж байгаа хууль тогтоомжууд нь өөрөө төсвийн өндөр эффе́кттэй батлагдаад, тухайн үедээ яг төсвийн нөлөөг нь ярихгүй явж байгаад хууль нь батлагддаг. Тэгээд яг төсөв дээр ирж байгаа нөлөөлөл нь бол маш өндөр ийм нөлөөтэй хуулиуд батлагдаад байгаа юм. Тэгэхээр ер нь бол цаашдаа яах ёстой юм бэ гэхээр яг энэ төсвийн өндөр нөлөөтэй хуулиуд орж ирж байгаа бол тухайн жилийнхээ төсвийн хүрээнээсээ өмнө эсвэл дараа нь ч юм уу батлагдаж байгаа бол энийг тухайн төсвийн цаглавартайгаа нийцүүлээд авах, үгүйгээ бол Засгийн газрын саналыг илүү өргөн хүрээнд хардаг байвал илүү зөв юм болов уу гэсэн ийм бодолтой байна.

Улсын төсвийн алдагдал хэрхэн санхүүжүүлсэн бэ гээд өнгөрсөн оны гүйцэтгэлээр улсын төсвийн гүйцэтгэл тэнцвэржүүлсэн орлого бол 807 орчим тэрбум төгрөгөөр тасарсан. Нийт орлогын дүн бол 673,6 тэрбумаар бол улсын төсөв дээр бол тасарсан. Нийт зардал талдаа бол бид нар урсгал зардлаа 1,2 их наядаар санхүүжүүлж чадаагүй. Хөрөнгийн зардал бол 950 орчим тэрбум төгрөгийн зардлыг бол бас мөн санхүүжүүлээгүй. Энэ дотроо хөрөнгийн зардлаа задлаад үзэх юм бол 770 орчим тэрбум нь яг цэвэр улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал. Энэ хөрөнгө оруулалтын зардлаас 270 орчим тэрбум төгрөгийнх нь зардлын санхүүжилтээ авах хүсэлтүүд бол тухайн үедээ ирсэн байсан. Гэхдээ улсын төсвийн орлогын бүрдэлтэй холбоотойгоор санхүүжүүлж чадаагүй. Үлдэх 500 гаруй тэрбум

төгрөгийн санхүүжилт бол угаасаа гүйцэтгэлээ авах хүсэлт нь ирээгүй гэсэн үг. Урсгал санхүүжилт дээр 1,2 их наяд төгрөгийн санхүүжилт гаргаж чадаагүй нь мөн түрүүний яг хэлж байгаа орлогын тасалдалтай холбоотой байгаад байгаа юм.

Дээрээс нь яагаад улсын төсвийн орлого өөрөө 800 тэрбум төгрөгөөр тасрахад зардал талдаа 2 их наядаар зардлыг санхүүжүүлж чадаагүй вэ гэдэг асуудал бол мэдээж яригдах ёстой. Үүний үндсэн суурь шалтгаан юу байсан бэ гэхээр нэгдсэн төсвийн суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцлийн төсвийн тусгай шаардлагууд бол байдаг. Энэ дотор байгаа шаардлагуудаа аваад үзэхээр нэгдсэн төсвийн гүйцэтгэлээ бол Сангийн яам байнгын сар, улирал болгоноор хараад явж байдаг. Нэгдсэн төсвөө харахаар орон нутгийн төсвийн харилцаа, орон нутгийн төсвийн хэтрэлттэй холбоотой, бусад төсвийн бүрэлдэхүүнүүдтэй холбоотой төлөвлөгөөний биелэлт дутуу байснаас үүдээд улсын төсвөөс санхүүжилт гаргахад хүндрэлтэй болж эхэлсэн. Энэ нь оны эцэс рүү бол бүр хүндрээд, улсын төсвөөсөө зарлага санхүүжилт гарч чаддаггүй, орон нутгийн төсвийн санхүүжилтүүд бол яваад байсан ийм асуудлууд бол байгаа гэдгийг хэлье.

Оюутолгойн урьдчилгаа төлбөрийн тухайд бол 2021 онд татварын маргаантай холбоотойгоор 1,1 их наядын төлбөр бол шилжиж орж ирсэн байдаг. Сүүлд 2026 оны 2 сар хавьцаа байх, 2 сард 1,6 их наядын татварын урьдчилгаа, татварын маргаан эхлэхээс өмнөх урьдчилгаа төлбөр бол орж ирсэн. Сүүлд орж ирсэн 1,6 их наядын хөрөнгө бол төрийн сан дээр өглөг буюу болзошгүй өр төлбөр хэлбэрээр бүртгэлтэй байгаа. 2021 онд орж ирсэн 1,1 их наядын төлбөр бол тухайн үедээ яг ковидын цаг үед бол байсан. Засгийн газрын шийдвэр гараад, тодорхой хэмжээгээр иргэдэд мөнгөн тусламж олгох ийм шийдвэр гаргаад, тухайн зарцуулалт нь бол гараад явсан байгаа.

Та нэмээд бас энэ нөгөө татварын орлоготой холбоотой урьдчилж орлого авсан энэ нь хууль зөрчиж байна уу гэдэг асуулт асуусан. Энэ бол Татварын ерөнхий хуулийн 28.1, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 25.2 гээд тухайн улиралд борлуулалт нь хийгдсэн аливаа ажил үйлчилгээ дээр тухайн татвар төлөгч нь өөрөө татварын ноогдлоо тодорхойлоод урьдчилаад төлөх эрх зүйн зохицуулалт бол хуулиараа олгогдчихсон байдаг. Үүнтэй холбоотойгоор 900 гаруй аж ахуйн нэгж бол тухайн тайлан тоондоо хийгдсэн ажил үйлчилгээндээ тохирох хэмжээний татварын урьдчилгааг бол төлсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Аудитаас би асуугаад байгаа зүйл нь энэ төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагатай холбоотойгоор Аудитын тухай хуульд орсон өөрчлөлтөөрөө та бүхний гаргасан зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авах, хариуцлага тооцох эрх зүйн үндсийг нь бид нар бүрдүүлж өгсөн юм. Тэгэхээр энэ асуудал нь 1 дүгээрт ямар нэг байдлаар төсвийг төлөвлөхдөө иргэдийн санал авах, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй ч гэдэг юм уу тийм бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдөхөөр байгаа. Хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалтын бусаар ашигласан бол тухайн төсвийн ерөнхийлөн захирагч дээр бас хариуцлага тооцохоор байгаа. Бүр дээрээс нь төлөвлөлттэй холбоотойгоор төсвийн төслийг нь боловсруулж батлуулахдаа үндэслэлгүй тоон мэдээн дээр тулгуурлан батлуулсан нь төсвийн гүйцэтгэлээр болоод аудитын зөвлөмжөөр тогтоогдсон бол ажил албанаас нь чөлөөлнө гэдэг асуудлууд байгаа. Тэгээд Монгол Улсын нийт энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын дунд ийм алдаа дутагдал, зөрчил байхгүй гэж аудитын байгууллага сүүлийн 2 жилийн хугацаанд дүгнэж үзэж байгаа юу. 4 номер.

С.Магнайсүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Яг одоо сөрөг дүгнэлт авчихсан, аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан ийм бас тохиолдлууд байгаа. Энэ бол аудитын хуулиар бол шууд хариуцлага байгаа. Энийг нь бол бид нар хариуцлагын асуудлыг тавьчихсан байгаа. Төсвийн хууль дээр заасан, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх, халах, чөлөөлөх гэсэн ийм 3 үндсэн зохицуулалтаар асуудлыг тусгасан. Чөлөөлөх асуудал бол яг хууль зүйн хувьдаа бол хариуцлагын асуудал биш. Чөлөөлөх нь бол тухайн эрх бүхий хуулиараа эрх олгогдсон тухайн субъектийн өөрийнх нь эрхийн асуудал байгаа учраас чөлөөлөх үндэслэл бүрдсэн байна шүү гэж хэлээд, бид нар 70.3, 70.4, 70.5-аар зөрчлийг нь ялгаад ингээд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт нь бол хүргүүлсэн байж байгаа. Бусад хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг болохоор бид нар аудит хийх явцдаа аудитын стандарт, норм дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлуудыг нь бол хөндчихсэн. 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар бид нар 252 хариуцлага хүлээлгэх албан шаардлагыг бол хүргүүлсэн байж байгаа. 18 асуудлыг бол хууль хяналтын байгууллагад гэмт хэргийн чанартай байж болзошгүй гэж шилжүүлсэн ийм дүн мэдээтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Сангийн яамны танилцуулга болоод аудитын тайлантай холбоотой үг хэлэх гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Би санал хэлье.

Аудитын байгууллагад, Сангийн яамныхан та нарт 1 дүгээрт би ажил хэрэгч санал тавьж байгаа юм. Энэ үндсэндээ татвар төлөгчдийн мөнгөн дээр бид нар бас сахилга бат, хариуцлагатай, төсвийн гүйцэтгэлийг хянадаг энэ процесс маань ч гэсэн өөрөө бас их ил тод, нээлттэй, үр дүнтэй байх зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр аудитын байгууллага төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх хугацаа, дэгтэй холбоотой асуудлууд дээр ажиллаад, энийг илүү үр ашигтай, үр дүнтэй болгох, сахилга бат, хариуцлагыг сайжруулах саналыг боловсруулъя. Би та бүхэнд 9 сарын 1 гэх хугацаатай үүрэг даалгаврыг Сангийн яам болоод Аудитын байгууллагад өгч байгаа. Бид нар үндсэндээ 6 сарын 15-нд төсвийн гүйцэтгэлийг Аудитын байгууллагаас өргөн барьсны дараагаас Улсын Их Хурал хэлэлцэж эхэлдэг.

Өнөөдөр 7 сарын 3-нд чуулган завсарлах гэж байна. Та бүхнийг 17-нд өргөн барьснаас хойш 26 буюу 9 хоногийн дотор өнөөдөр Улсын Их Хурлын бүх Байнгын хороодууд ингээд хэлэлцсэн болоод өнгөрч байна. Хэлэлцсэн болоод өнгөрч байна. Бид нар ийм байдлаар татвар төлөгчдийн мөнгөн дээр, төсөв дээр ийм хариуцлагагүй хандаж болмооргүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хэлэлцэх дэгийг илүү ил тод, нээлттэй, хариуцлагатай болгоно. Болж өгвөл та бүхэн өөрсдөө судлаад 6 сарын 15 хүртэл биш 4 сарын 15 гэхэд аудитынх нь дүгнэлт, зөвлөмжийг өргөн барьдаг гэдэг юм уу ийм жишиг рүү оруулаад, Улсын Их Хурал ядаж энэ дээр чинь гүйцэтгэлийг нь 2 сар гаруй гар дээрээ материалыг нь аваад, 1-д нэгэнгүй үзээд, ард олон нийтэд хүргээд, олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг хийгээд, магадгүй Улсын Их Хурлын хэмжээнд сонсгол хийж, гүйцэтгэлийг хянадаг энэ механизм хэрэгтэй байх гэж би харж байгаа. Ирэх оноос эхлээд. Ирэх оноос эхлээд. Ингэж байж бид нар гүйцэтгэл дээрээ гаргасан алдаагаа дараа жилийнхээ төлөвлөлт дээрээ гаргахгүй байх, залруулах боломж, бололцоо бүрдэнэ. Бүр тухайлаад яг энэ удаагийнх шиг өнөөдөр Засгийн газраас 10, 20 хуулийн төслүүдийг өргөн бариад, бүх Байнгын хороодыг ачаалалтай ажиллуулаад хоёрхон 7 хоногийн дотор төсвийнхөө гүйцэтгэлийг дундуур нь шургуулаад ингээд гаргаж байгаа энэ дэг зарчим бол болохгүй. Тэгэхээр бид нар Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ магадгүй Улсын Их Хурал тухайн тэр хяналтын сонсгол хийхэд тухайн тэр цаг мөчид, тэр 2-3 хоногт гэдэг юм уу, тэр 7 хоногт ямар нэг өөр асуудлуудыг

хэлэлцдэггүй байх, Улсын Их Хурлын бүх гишүүд, Улсын Их Хурал, олон нийт энэ асуудалд бүрэн дүүрэн анхаарлаа хандуулах энэ цаг хугацаа боломж, бололцоог Их Хурлын хэлэлцэх дэгийнх нь хүрээнд ч, хоног хугацааных нь хүрээнд ч боломж олгох зайлшгүй шаардлагатай байгаад байгаа. Сангийн яаманд ч гэсэн энэ алсдаа хэрэгтэй. Бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр гарч байгаа алдаануудыг та бүхэн бас олж илрүүлж, төлөвлөлт дээрээ бас алдахгүй байх энэ зарчим өөрөө хэрэгтэй байгаа. Тэгэхээр энэ зарчмыг та бүхэн 1 дүгээрт 9 сарын 1-ний өмнөөс саналыг нь боловсруулаач. Бид бүхэнд танилцуулаач. Тэгээд болж байвал ирэх оныхоо төсөвтэйгөө хамт, тодотголтойгоо хамт энийгээ өргөн барь. Яагаад вэ гэвэл энэ эдийн засгийн чинь салшгүй 1 хэсэг, гол үндсэн фактор нь өөрөө төсөв өөрөө болоод байна. Инфляц чинь сараас сард өөрөө 1-1,5 функтээр нэмэгдээд байна. Өнөөдөр 11,6 хувь гэж ярьж байгаа боловч энэ чинь дараагийн сард дахиад 1 хувиар нэмэгдэх нь. Намар хүрэхэд бид нар юу болохыг мэдэхгүй. Алдаа оноогоо зөв оношлохгүй бол ингээд төсвийн нэрийн доор импортынхоо бараа бүтээгдэхүүн, энэ инфляцад нөлөөлдөг зүйлүүдээ нэмэгдүүлээд байж ингэж боломгүй байгаад байгаа юм. Тэгэхээр тийм түвшиндээ 1 дүгээрт ажиллая.

2-т магадгүй энэ оных бол ингээд нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг аргацаагаад ингээд өнгөрлөө. Шаардлагатай бол бид нар ирэх оны төсвийг чинь өргөн барьсан 9 сарын хугацаанд хууль, эрх зүйн орчин байхгүй ч гэсэн Улсын Их Хурлын гишүүн санаачлаад 2025 оны төсөв дээр хяналтын сонсголыг бас хийх эрх бол нээлттэй байгаа. Ер нь бол хийх нь зүйтэй гэж үзэж байна. Тэгээд тэр дээр бол та бүхэн бас бэлтгэлтэй байх хэрэгтэй. 1 бүрчлэн бид бүхэн саяын хэлсэн асуудлууд дээр аудитад олгосон эрх мэдэл, хэм хэмжээнүүд дээр хэрхэн ажилласан юм гэдэг асуудлуудыг ч гэсэн бид нар бас ярих зайлшгүй шаардлагатай байгаа. Ийм саналтай байна. Эдгээр асуудлууд дээр та бүхэн бас хариуцлагатай ажиллаарай. Татвар төлөгчдийн мөнгөн дээр бид нар хариуцлагатай хандах, энийг бас үр ашиг, сахилга батыг нь дээшлүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Ийм саналтай байна. Баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах байгаа. Зарлагын дэд хорооны гишүүн манай Байнгын хорооноос хэн байгаа билээ. Лүндэг гишүүн танилцуулах уу. Тэгье. Лүндэг гишүүн танилцуулъя.

Ингээд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Албан тушаалтнуудад баярлалаа. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан байна.

Хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүддээ бас баярлалаа.

15.20 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ